



БОЛОВСРОЛЫН  
ЯАМ

№ 03/6.1-2. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хяналтын байгууллага:

Шалгуулагч этгээдийн нэр:

Объектын нэр:

Регистрийн дугаар:

Хяналт шалгалтын удирдамжийн дугаар:

Хяналт шалгалт эхэлсэн огноо:...../...../.....

Хяналт шалгалт дууссан огноо:...../...../.....

Шаардлага хангасан  
асуултын тоо:

Хууль сахин  
мөрдөлтийн хувь:

Шаардлага хангаагүй  
нийт оноо:

Эрсдэл үүсэх  
магадлалын хувь:

Эрсдэл үүсэх  
магадлал

II. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл, заалт	Шалгуур	Батлагдсан оноо		Авсан оноо	Гүйцэтгэлийн шалгалт
			Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй		
1	2	3	4	5	6	
<b>I.УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b>			<b>0</b>	<b>115</b>		
1	Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.1, 7.3, 7.7 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 19.1, 19.3, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 18.1	Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй.	0	10		
2	Боловсролын ерөнхий хуулийн 34.2, 33.3.1, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 23.2, 24.7, “Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 3.2, “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 1.2, 1.3, 2.1, 4.8	Сургуулийн зөвлөл, Удирдах зөвлөл нь чиг үүргээ хэрэгжүүлэн ажилладаг. Зөвлөлийн шийдвэр, хурлын тэмдэглэл, бусад баримт бичгийг байгууллагын архивт хадгалдаг.	0	20		
3	Боловсролын ерөнхий хуулийн 33.3.1, 34.2, 40.1.3, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17.1.1, “Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 1.1, 1.5, 1.6, 3.3.3.1, 3.3.3.3, 3.3.3.4, 3.5, 4.9, 7.3	Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны бодлого, төлөвлөгөө, дүрэм, журам, заавар боловсруулах, хэрэгжүүлэхэд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, олон нийт санал өгөх боломж бүрдүүлсэн.	0	10		
4	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 25.1, 25.2, 25.4, “Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 3.4, 7.2	Сургуулийн мэргэжил арга зүйн хамтын удирдлагыг багш нарын зөвлөл, мэргэжлийн багш нарын бүлэг хэрэгжүүлэн ажилладаг.	0	10		

5	Боловсролын ерөнхий хуулийн 33.3, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17.1.2, 17.1.3, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 3.3	Багш, ажилтны тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж, ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлдэг.	0	5		
6	Боловсролын ерөнхий хуулийн 12.11, 12.13, 33.3.1, 33.3.3, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 5.2, 7.1, 7.3, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 16.4, 16.5, 17.1.1, 17.1.2, 25.2.1, 25.2.2, 25.4, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 3.4	Багшийн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлон хөгжлийг дэмжих хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажилладаг.	0	5		
7	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23.1, 23.2, 23.4, 23.5, 23.6, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17.1.5, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.7, 2.2.14, 3.7, "Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам"-ын 3.2.2, 3.5.4, 5.2	"Хүүхэд хамгааллын бодлого", "Хүүхэд хамгааллын дүрэм" баталж мөрддөг, "Хүүхэд хамгааллын баг" нь хүүхдийн эрх хамгаалал, хөгжлийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, гүйцэтгэл, үр дүнг тооцдог.	0	10		
8	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14.2, 14.3, 14.5, Боловсролын ерөнхий хуулийн 10.1.9, 17.9, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17.1.5, 18.5, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 3.7	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээ, эрүүл мэндийн бодит байдалд нийцүүлэн хөгжих, сурах эрхийг хангах орон тооны бус "Дэмжлэгийн баг" нь чиг үүргээ хэрэгжүүлэн ажилладаг.	0	10		
9	Боловсролын ерөнхий хуулийн 33.3.1, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17.1.5	Холбогдох мэргэжлийн байгууллагаас баталсан гамшиг, онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах төлөвлөгөө гарган мөрддөг.	0	5		
10	Боловсролын ерөнхий хуулийн 33.3.1, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17.1.10	Төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилттэй холбоотой тайлан мэдээллийг "Сургуулийн зөвлөл", хамт олон, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд ил тод, нээлттэй, ойлгомжтой байдлаар мэдээлдэг.	0	5		
11	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17.1.5, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 5.7, "Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам"-ын 3.4.1	Сургууль орчмын хяналтын камерыг ашиглах, бичлэг хадгалах, хянах дүрэм, журам батлан мөрддөг.	0	5		
12	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9.1.1, 10.1, 12.1.1, 12.1.2, 12.1.5, Засгийн газрын "Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай" 109 дүгээр тогтоолын 2, "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм"-ийн 6.1, 6.2, 6.5	Багш, ажилтны ёс зүйн дүрмийг багш, ажилтанд танилцуулж, ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах, хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, багш, ажилтны албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд тусган хэрэгжүүлдэг.	0	20		

II. СУРГАЛТЫН ОРЧИН		0	245			
II.I Гадаад орчинд тавигдах шаардлага, аюулгүй байдал		0	115			
13	Боловсролын ерөнхий хуулийн 39.1, 39.6, 39.9, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.4, 3.3.3.6	Үйл ажиллагаа явуулж буй барилга, байгууламж нь зориулалтын, стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан.	0	20		
14	Боловсролын ерөнхий хуулийн 39.1, 39.5, 39.6, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 5.1, 7.7, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.4	Сургалтад зориулсан эзэмшил газартай, тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл саадгүй нэвтрэх боломжтой, инженерийн шугам сүлжээний байгууламж, суваг, худгийг аюулгүй, эрсдэлгүй байлгадаг.	0	10		
15	Боловсролын ерөнхий хуулийн 39.1, 39.8, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 5.2.1, 5.2.2	Барилга нь галын болон аюулгүй байдлын дохиоллын систем, галын дүгнэлт, стандартын шаардлага хангасан аянга зайлуулагчтай.	0	10		
16	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 5.1.3, Боловсролын ерөнхий хуулийн 39.1, 39.9, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 5.2.6, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 3.3.3, "Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам"-ын 3.1, 4.1	Сургуулийн барилга, анги танхим, ариун цэврийн өрөө нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн зорчих, суралцах үйлийг дэмжсэн орчин бүрдүүлсэн.	0	10		
17	Боловсролын ерөнхий хуулийн 39.1, 39.8, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17.1.5, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 7.1, 7.2, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 3.3.3.1, 3.3.3.6	Сургууль орчмын авто зам нь хурд сааруулагчтай, аюулгүйн тэмдэг, тэмдэглэгээтэй, суралцагчийн аюулгүй байдлыг хангасан.	0	10		
18	Боловсролын ерөнхий хуулийн 39.1, 39.8, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17.1.5, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 6.8.3, 6.8.4, 6.8.5, 6.8.6, 6.8.7, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 3.3.3.1, 3.3.3.6	Сургуулийн шатны орчинд халтирах, унахаас сэргийлэх таних тэмдэг, тэмдэглэгээн байршуулсан, хашлага хоорондын зайд хамгаалалт хийсэн.	0	5		
19	Боловсролын ерөнхий хуулийн 39.1, 39.8, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17.1.4, 17.1.5, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 5.3, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 3.3.3.1, 3.3.3.6	Биеийн тамирын талбайн хашаа, хэрэглэлийг бат бэх, хөдөлгөөнгүй суурилуулж, бүрэн бүтэн байдал аюулгүйн шаардлагыг хангасан.	0	10		

20	Боловсролын ерөнхий хуулийн 39.1, 39.8, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17.1.4, 17.1.5, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 5.3, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 3.3.3.1, 3.3.3.6	Сургалт-туршилтын талбайтай, бүтээцийг бат бөх хөдөлгөөнгүй суурилуулж, бүрэн бүтэн байдал аюулгүйн шаардлагыг хангасан.	0	10		
21	Боловсролын ерөнхий хуулийн 39.1, 39.8, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17.1.4, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандарт, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 3.3.3.4, 3.3.3.6	Сургуулийн гадаад, дотоод орчны нөхцөл байдлын зураглал гарган эрсдэлийн үнэлгээг улирал тутам хийдэг, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлдэг.	0	10		
22	Боловсролын ерөнхий хуулийн 39.1, 39.8, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 12.1.1, 17.1.5, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 5.7, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 3.3.3.1, 3.3.3.6	Сургуулийн орчныг бүхэлд нь хянах боломжтой шаардлага хангасан хяналтын камертай /хугацаа хүчинтэй, хадгалах хоног 30-аас дээш/	0	10		
23	Тамхины хяналтын тухай хуулийн 5.2.4, 6.7.14, 9.1.8	Хичээлийн байраас 500 метрийн дотор тамхи худалдаалах цэггүй, нийтийн бие засах газар болон дотоод, гадна орчинд тамхи татахыг хориглосон анхааруулга, зөвлөмж, санамжийг байршуулсан.	0	10		
<b>II.II Дотоод орчинд тавигдах шаардлага, аюулгүй байдал</b>			<b>0</b>	<b>130</b>		
24	Боловсролын ерөнхий хуулийн 39.1, 39.8, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.2, 17.1.5, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 6.1	Сургуулийн барилга байгууламжийн аюулгүйн гарц нь ашиглахад бэлэн, гарах урсгал хөдөлгөөнийг харуулсан зураг, схем, аваарын гэрэл, дохио тэмдэглэгээ гэрэлтдэг, гарц бүрт байршуулсан.	0	5		
25	Боловсролын ерөнхий хуулийн 39.1, 39.8, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.2, 17.1.5, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 5.2, 6.4	Галын аюулгүй байдлын арга хэмжээний төлөвлөгөөтэй, галын болон гэнэтийн аюулын үед аврах арга хэмжээний бүдүүвч зургийг ил тод харагдахуйц байрлуулсан, гал унтраах анхан шатны бусад багаж хэрэгсэлтэй	0	10		
26	Боловсролын ерөнхий хуулийн 39.1, 39.8, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.2, 17.1.5, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 6.1.10	Хүүхэд унаж бэртэхээс сэргийлж цонхны салхивчны онгойх өнцгийг хязгаарласан түгжээтэй, хэрэв цонхны тавцан шалнаас 1 метрийн өндөрт байрлах тохиолдолд хамгаалалтын хаалттай.	0	5		

27	Боловсролын ерөнхий хуулийн 33.3.1, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 18.2, 22.1, 22.3, 22.6, "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам"-ын 4	Бүлэг дүүргэлтийг бага ангид 30-35 /багийн салбар бүлэгт 20-оос доошгүй/, дунд, ахлах ангид 32-35, ахлах ангийн мэргэжлийн болон сонгон судлах хичээлийн бүлэгт 25-30, харах, сонсох эрхтэний хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн бүлэгт 8-12, оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн бүлэгт 10-15 хүүхэдтэй байхаар зохион байгуулдаг. /Цахим сургуулийн бүлэгт 20-иос ихгүй/	0	5		
28	Боловсролын ерөнхий хуулийн 16.1, 16.2, 39, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.2, 11.10, 17.1.4, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 6.11, 6.13	Суралцагчийн ялгаатай хэрэгцээг хангах түгээмэл загвар, сургалтын тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин нөхцөлийг бүрдүүлсэн.	0	5		
29	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14.2, Боловсролын ерөнхий хуулийн 39.1, 39.8, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.2, 17.1.5, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 6.9, 6.10	Сургалтын орчин нөхцөл, аюулгүй байдлыг хангасан Хүүхэд хөгжлийн танхимтай.	0	5		
30	Боловсролын ерөнхий хуулийн 8.3, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 10.7, 15.2, 18.4, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.3, 2.2.6,	Суралцагчийн ялгаатай хэрэгцээнд тохируулан хичээл, сургалтыг уян хатан арга хэлбэрээр зохион байгуулж, дэмжлэг үзүүлдэг, ганцаарчилсан сургалт зохион байгуулах танхимтай.	0	5		
31	Боловсролын ерөнхий хуулийн 39.1, 39.8, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.2, 17.1.5, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 6.11, 6.14, "Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори байгуулах, ашиглах журам"-ын 2, 3, 4	Хөгжмийн хичээл, сургалтын үйл ажиллагааг орчин нөхцөл, аюулгүй байдлыг хангасан кабинет /урлаг соёлын танхим/-д зохион байгуулдаг.	0	5		
32	Боловсролын ерөнхий хуулийн 16.1, 16.2, 39, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.2, 11.10, 17.1.4, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 6.11, 6.13	Биеийн тамирын хичээл, сургалтын үйл ажиллагааг орчин нөхцөл, аюулгүй байдлыг хангасан зааланд зохион байгуулдаг.	0	5		
33	Боловсролын ерөнхий хуулийн 39.1, 39.8, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.2, 17.1.5, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 6.11, "Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори байгуулах, ашиглах журам"-ын 3.2, 3.8, 3.11	Цахим сургалтыг орчин нөхцөл, аюулгүй байдлыг хангасан, цахим хэрэглэгдэхүүнээр тоноглогдсон, утастай болон утасгүй сүлжээний орчинд зохион байгуулж, сургалтын материал, интерактив хичээл, контент, цахим сурах бичгийг суралцагч ашигладаг.	0	5		

34	Боловсролын ерөнхий хуулийн 39.1, 39.8, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.2, 17.1.5, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 6.11, "Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори байгуулах, ашиглах журам"-ын 2, 3, 4	Байгалийн шинжлэлийн /физик, биологи, хими/ хичээл, сургалтын үйл ажиллагааг орчин нөхцөл, аюулгүй байдлыг хангасан кабинет, лабораторид зохион байгуулдаг.	0	5		
35	Боловсролын ерөнхий хуулийн 39.1, 39.8, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.2, 17.1.5, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 6.11, "Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори байгуулах, ашиглах журам"-ын 2, 3, 4	Технологийн хичээл, сургалтын үйл ажиллагааг орчин нөхцөл, аюулгүй байдлыг хангасан кабинет, дадлагын газарт зохион байгуулдаг.	0	5		
36	Боловсролын ерөнхий хуулийн 39.1, 39.8, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.2, 17.1.5, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 6.11, "Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори байгуулах, ашиглах журам"-ын 2, 3, 4	Мэдээлэл зүйн хичээл, сургалтын үйл ажиллагааг орчин нөхцөл, аюулгүй байдлыг хангасан кабинет, лабораторид зохион байгуулдаг.	0	5		
37	Боловсролын ерөнхий хуулийн 39.1, 39.3, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.2, 11.10, 17.1.4, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 6.11, "Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори байгуулах, ашиглах журам"-ын 3.5, 3.6	Байгалийн шинжлэлийн /физик, биологи, хими/ лабораторид туршилтын ширээ сандал, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, урвалж бодис нь хүрэлцээтэй, аюулгүй байдлыг хангасан.	0	5		
38	Боловсролын ерөнхий хуулийн 16.1, 16.2, 39, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.2, 11.10, 17.1.4, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 6.11	Технологийн кабинет, дадлагын газарт дадлага ажлын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал /хамгаалах хувцас, нүдний шил, бээлий гэх мэт/ хүрэлцээтэй, аюулгүй байдлыг хангасан.	0	5		
39	Боловсролын ерөнхий хуулийн 16.1, 16.2, 39, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.2, 11.10, 17.1.4, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 6.11	Гадаад хэлний кабинетад техник хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн хүрэлцээтэй, аюулгүй байдлыг хангасан.	0	5		
40	Боловсролын ерөнхий хуулийн 16.1, 16.2, 39, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.2, 11.10, 17.1.4, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 6.11, 6.14	Хөгжмийн кабинет /урлаг, соёлын танхим/-д хөгжмийн зэмсэг, техник хэрэгсэл хүрэлцээтэй, аюулгүй байдлыг хангасан.	0	5		

41	Боловсролын ерөнхий хуулийн 39.1, 39.8, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.2, 17.1.5, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 6.8.8	Сургууль болон ангийн хувцасны өлгүүр нь хүүхдийн биеийн өндөрт тохирсон, бэхэлгээ сайтай, хөдөлгөөнгүй, хувцас өлгөх дэгээ нь хурц үзүүргүй.	0	5		
42	Боловсролын ерөнхий хуулийн 39.1, 39.8, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.2, 17.1.5, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 6.10	Анги, танхим, хонгилын шүүгээ, тавилгыг хананд бэхлэн хөдөлгөөнгүй байршуулж, ирмэгт нь хамгаалалт хийсэн.	0	10		
43	Боловсролын ерөнхий хуулийн 39.1, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 18.12, "MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын 6.12 "MNS5742:2019 Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага" стандартын 4.1.4, 4.4.2, 4.5.6, 8.1, 8.3, 8.5, 8.7, 9.6, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.10	Багш, суралцагчийн сурч, хөгжих үйл явцыг дэмжихэд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх стандартын шаардлага хангасан номын сантай.	0	10		
44	Боловсролын ерөнхий хуулийн 39.1, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 18.12, "MNS5742:2019 Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага" стандартын 4.1.4, 4.4.2, 4.5.6, 8.1, 8.3, 8.5, 8.7, 9.6, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.10, "Зайн болон цахим сургалт зохион байгуулах, эзэмшсэн боловсролыг үнэлэх, дүйцүүлэх журам"-ын 3.7	Номын сан нь нээлттэй ашиглах боломжтой цахим ном, гарын авлагын нэгдсэн сантай, ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн	0	10		
45	Боловсролын ерөнхий хуулийн 39.1, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 11.7, 18.12, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.10	Номын сангаар бага, дунд боловсролын агуулгын хүрээнд нийцсэн ном хүрэлцээтэй, суралцагчид сурах бичгээр бүрэн хангагдсан	0	5		
<b>III. ХҮНИЙ НӨӨЦӨД ТАВИХ ШААРДЛАГА</b>			<b>0</b>	<b>110</b>		
46	Боловсролын ерөнхий хуулийн 33.1, 33.2, 33.5, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 14.3, 14.5, 17.2, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 3.3.1, 3.3.2	Сургуулийн захирал, сургалтын менежер нь хуульд заасан шаардлагыг хангасан, эзэмшсэн мэргэжил, ажлын дадлага, туршлага нь албан тушаалын тодорхойлолтод тавигдах шаардлагад нийцсэн.	0	20		
47	Боловсролын ерөнхий хуулийн 12.1, 33.3.1, 33.3.2, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.7, 6.8, 14.3, 14.4, 16.1, 16.2, 16.3, 17.1.2, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 3.3.1, 3.3.2	Мэргэжлийн багшаар хангагдсан, холбогдох хууль тогтоомжид заасан бусад ажилтан ажилладаг.	0	20		
48	Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 16.2, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.8, 16.1, 16.2, 16.6	Багш бус мэргэжлийн хүн заах арга зүйн сургалтад хамрагдаж, багшлах эрхийн гэрчилгээ авсан.	0	10		

49	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 14.3, 17.3, "MNS 6949:2021 Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага" стандарт, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 4.7	Сургуулийн нийгмийн ажилтан нь мэргэжлийн /мэргэшсэн байх/, суралцагч, тэдний эцэг, эхэд мэргэжлийн үйлчилгээг үзүүлж, дэмжлэг үзүүлдэг.	0	20		
50	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 14.3, 17.4,	Сургуулийн сэтгэл зүйч нь мэргэжлийн, суралцагч, тэдний эцэг, эхэд мэргэжлийн үйлчилгээг үзүүлж, ганцаарчилсан болон бүлгээр сэтгэл зүйн дэмжлэг, үйлчилгээ үзүүлдэг.	0	20		
51	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 14.3, Номын сангийн тухай хуулийн 10.3, 11, "MNS 5742:2019 Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага" стандартын 10	Номын санч нь мэргэжлийн /мэргэшсэн байх/, багш, суралцагчийн сурч, хөгжих үйл явцыг дэмжихэд чиглэсэн номын сангийн үйлчилгээ үзүүлдэг.	0	20		
<b>Ү. СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>			<b>0</b>	<b>210</b>		
52	Боловсролын ерөнхий хуулийн 14, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 5, 9, 10, 20.1, 20.5, 20.6, 20.8, 20.9, 20.13, БШУ-ны сайдын 2023 оны А/350 "Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай", А/398 "Тушаалд өөрчлөлт оруулах тухай"	Сургалтын агуулга, хөтөлбөр, төлөвлөгөөг холбогдох хууль, стандарт, тушаал, дүрэм, журамд нийцүүлэн баталж, мөрддөг.	0	20		
53	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 20.5, 20.8, "Төрөлжсөн ахлах сургуулийн талаар баримтлах чиглэл" Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 20.5, 20.6, 20.8, 20.9, "Төрөлжсөн ахлах сургуулийн талаар баримтлах чиглэл"	Суралцагчийн авьяас, чадварыг хөгжүүлэх төрөлжсөн сургалт зохион байгуулдаг.	0	20		
54	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14, 15, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.3, 6.5, 7.4	Ялгаатай хэрэгцээтэй суралцагчид зориулан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн санал, зөвшөөрлийг үндэслэн боловсруулж, тэдний оролцоо, дэмжлэгтэйгээр хэрэгжүүлдэг.	0	20		
55	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 15.1, 18.7, 20.1, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.1, 2.2.2, 2.2.3, 2.2.5, 3.4.3, 3.4.5	Бага боловсролын стандартын хэрэгжилтийн ахиц, үр дүнг тооцдог, стандартын хэрэгжилтийг сайжруулах ажил зохион байгуулж, үр дүнд хүрсэн.	0	20		
56	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 15.1, 18.7, 20.1, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.1, 2.2.2, 2.2.3, 2.2.5, 3.4.3, 3.4.5	Суурь боловсролын стандартын хэрэгжилтийн ахиц, үр дүнг тооцдог, стандартын хэрэгжилтийг сайжруулах ажил зохион байгуулж, үр дүнд хүрсэн.	0	20		
57	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 15.1, 18.7, 20.1, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.1, 2.2.2, 2.2.3, 2.2.5, 3.4.3, 3.4.5	Бүрэн дунд боловсролын стандартын хэрэгжилтийн ахиц, үр дүнг тооцдог, стандартын хэрэгжилтийг сайжруулах ажил зохион байгуулж, үр дүнд хүрсэн.		20		

58	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 15.1, 18.7, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.1, 3.4.3, "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам"-ын 1.2, 3.1, 6.9	Сургуулийн сургалтын чанарын үнэлгээний дундаж 40 хувьд хүрсэн.		20		
59	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 15.1, 18.7, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.1, 3.4.3, "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам"-ын 1.2, 3.1, 6.9	Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээ /анги дэвших болон сургууль төгсөх шалгалт/, хөндлөнгийн үнэлгээгээр сургуулийн дундаж 70-аас дээш хувийн үнэлгээтэй.		10		
60	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 15.1, 18.7, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.1, 3.4.3, "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам"-ын 1.2, 3.1, 6.9	Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэсэн сургуулийн өөрийн үнэлгээ, боловсролын үнэлгээний төв болон мэргэжлийн байгууллагын хөндлөнгийн үнэлгээний зөрүү 10 хувиас бага.		10		
61	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 15.1, 18.7, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.13	Элсэлтийн шалгалтын сургуулийн дундаж нь 500 ба түүнээс дээш онооны үзүүлэлттэй.		10		
62	Боловсролын ерөнхий хуулийн 12, 11.2, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 15.1.4, 15.3, 17.2, Багшийн хөгжлийг дэмжих тухай 10.1	Багшийн ажлын байранд өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боллоцоог хангаж, сургалтын менежер нь сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар ханган хамтарч ажилладаг.	0	20		
63	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14, 15, Боловсролын ерөнхий хуулийн 13.2.2, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 15.2, 15.3, 22.2, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.3, 2.2.6	Суралцагчийн ялгаатай хэрэгцээ, онцлог, ачаалалд тохирсон, тэдний бүтээлч сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх, бие даан ажиллах чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн цахим даалгаврын сан бүрдүүлдэг.	0	20		
<b>Ү. СУРАЛЦАГЧИЙН ХӨГЖИЛ, ТӨЛӨШИЛ, ХАМГААЛАЛ</b>			<b>0</b>	<b>170</b>		
64	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 12.1.3, 20.10, 20.11, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.2, 2.2.6	Суралцагчийн суралцах, хөгжил төлөвшлийг дэмжих, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаа дугуйлан, секц нь хүртээмжтэй.	0	20		
65	Биеийн тамир, спортын тухай хуулийн 16.2.3, "Суралцагчийн бие бялдрын хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" тушаалын 1.1, 1.3	Суралцагч, багш, ажилтанд идэвхтэй хөдөлгөөн хийх, спортоор хичээллэх боломжийг бүрдүүлж, спорт заалыг төлбөргүй ашиглуулдаг.	0	10		
66	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23.2.5, "Боловсролын сургалтын байгууллагын орчинд /сургуулийн орчинд/ электрон тамхи хэрэглэхийг хориглох тухай" тушаалын 1, 2	Электрон тамхины хор уршиг, эрүүл мэндэд үзүүлэх хор нөлөөний талаар сургалт, нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг.	0	10		
67	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 15.1.3, 23.2.5 "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.6, 2.2.8, 3.7	Суралцагч хоорондын болон эцэг эх, багш, ажилтны харилцааны зөрчил, хүүхдэд тулгарсан бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлдэг.	0	20		

68	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 15.1.3, 23.2.5, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.6, 2.2.8, 3.7	Хүүхдийг сурлагын амжилт, нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, амьдралын нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхагдахаас хамгаалах орчин бүрдүүлсэн, асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлдэг.	0	20		
69	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 15.1.3, 23.2.5, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.6, 2.2.8, 3.7	Хүүхдийг бие махбод, сэтгэл санааны шийтгэл, хүчирхийлэл, үл хайхрах байдалд өртөх, гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулж, үр дүнг нь тооцдог.	0	20		
70	Боловсролын ерөнхий хуулийн 10.1.9, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 12.1.4, 18.10, 18.11, 20.10, 20.12, "MNS 6781:2019 Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага" стандартын 6.2.5, 6.3.6, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.6, 2.2.7, "Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам"-ын 3.1	Авьяас чадварыг хөгжүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн онцлогтой танилцах, сонирхсон мэргэжлийнхээ дагуу судалгаа хийх аргад суралцах чиглэлээр сургалт зохион байгуулдаг.	0	20		
71	Боловсролын ерөнхий хуулийн 10.1.9, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 12.1.4, 18.10, 18.11, 20.10, 20.12, "MNS 6781:2019 Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага" стандартын 6.2.7, 6.3.6, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.6, 2.2.7	Гэмт хэрэг зөрчил, халдварт өвчин, архи тамхины нөлөө, хорт зуршил, компьютер тоглоомд донтох, цахим орчноос өөрийгөө болон найз нөхдөө хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулдаг.	0	20		
72	Боловсролын ерөнхий хуулийн 13.2.8, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 15.1.2, "MNS 6781:2019 Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага" стандартын 6.3.1, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.7, 5.10, "Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам"-ын 3.1, 3.2, 3.4, 3.5, 3.6, 4.5	Багш, ажилтан нь Хүүхэд хамгааллын бодлого, төлөвлөгөөтэй танилцаж баталгаажуулсан, багш, ажилтны жилийн ажлын үнэлгээнд хүүхэд хамгааллын чиглэлээр хийсэн ажлыг тооцдог.	0	20		
73	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 15.1.3, 23.2.5, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.6, 2.2.8, 3.7	Цахим орчны нөлөөнд өртөх, ялгаварлан гадуурхагдах тохиолдолд тусламж авах арга замыг хүүхэд бүр мэддэг.	0	10		
<b>ҮІ. ДОТООД ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ</b>			<b>0</b>	<b>110</b>		
74	Боловсролын ерөнхий хуулийн 35.7, 35.8, "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.5, 3.7.3, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 3.7	Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам, төлөвлөгөөний дагуу хийж, бүртгэл хөтлөн мэдээллийн сан бүрдүүлсэн.	0	20		

75	"Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.7.3, 3.7.4, 3.7.6, 5.1, 5.2	Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээ авч ажилладаг, хариуцлага тооцдог.	0	10		
76	Боловсролын ерөнхий хуулийн 40.1	Эцэг эх, асран хамгаалагчид цэцэрлэгийн үйл ажиллагааны талаар мэдээлэл, зөвлөгөө чөлөөтэй авах, хяналт тавих нөхцөл бүрдүүлсэн.	0	10		
77	"Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.1, 3.2, 3.3, 3.4, 3.5	"Сургуулийн зөвлөл"-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон хурлын шийдвэрийн хэрэгжилт, тэдгээрийг сургуулийн албан ёсны цахим хуудас, эсхүл мэдээллийн самбарт ил тод, нээлттэй байршуулж мэдээлдэг.	0	10		
78	Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 12.4, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 3.7, "Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам"-ын 3.6.2	Багшийн ёс зүйн дэд хороо /зөвлөл/-той, багш, ажилтны зүй бус, ёс зүйгүй үйлдлийн тухай үнэн зөв, бодит мэдээллийг хүлээн авах, шалгах, хариу арга хэмжээ авах тухай "Мэдээллийн журам" боловсруулан мөрддөг.	0	10		
79	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17.1.5, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.7, 2.2.8, 2.2.13, "Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам"-ын 4.2, 6.1, 6.2	Захирал нь хичээлийн жилийн төгсгөлд сургуулийн үйл ажиллагаанд талуудын оролцоотой эрсдэлийн үнэлгээ хийж, тайланг хамт олон, эцэг эх, сургуулийн зөвлөлд танилцуулсан.	0	10		
80	Боловсролын ерөнхий хуулийн 35.2, 35.7, "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 2.2, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 3.3.1	Сургалт, үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол болон дотоод хяналт, үнэлгээний дүн, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үүрэг даалгаврын биелэлтийг харгалзан үзнэ.	0	20		
81	Боловсролын ерөнхий хуулийн 17.1.5, 37.2.1, 37.2.4, 40.2.5, 40.2.6, "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.5, 3.7.3, "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 3.7, 5.10.4	Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг хамарсан урлаг, спортын уралдаан, тэмцээн зохион байгуулахгүй байх, тэднээс хуульд заагаагүй төлбөр, хураамж, хандив, хуримтлал албадан цуглуулахгүй байхад хяналт тавьж ажилласан	0	10		
82	Боловсролын ерөнхий хуулийн 17.1.6, "Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих орон тооны бус хяналтын зөвлөлийн ажиллах журам"-ын 3.5, 3.6, 4.4	Гал тогоо, хоолны газар болон хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд дотоод хяналтыг хэрэгжүүлж, мэдээллийн сан үүсгэсэн.	0	10		
<b>НИЙТ ОНОО</b>			<b>0</b>	<b>960</b>		

**III. ХЯНАЛТ ШАЛГАЛТААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ, БИЕЛЭЛТ**

<b>ХЯНАЛТ ШАЛГАЛТААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ:</b> ..... ..... .....		
<b>БИЕЛЭЛТ:</b> ..... ..... .....		
<b>БАТАЛГААЖУУЛАЛТ</b>		
<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>	<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>	<i>Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан</i>
/ овог, нэр/	/ овог, нэр/	/ овог, нэр/
/ гарын үсэг, тэмдэг/	/ гарын үсэг, тэмдэг/	/ гарын үсэг, тамга/

Тайлбар:.....  
.....  
.....

**IV. ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГАЛТААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ, БИЕЛЭЛТ**

<b>ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГАЛТААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ:</b> ..... ..... .....		
<b>БИЕЛЭЛТ:</b> ..... ..... .....		
<b>ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГАЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ</b>		
Хяналт шалгалт хийсэн огноо: 20__ он __ сар __ өдөр		
<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>	<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>	<i>Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан</i>
/ овог, нэр/	/ овог, нэр/	/ овог, нэр/
/ гарын үсэг, тэмдэг/	/ гарын үсэг, тэмдэг/	/ гарын үсэг, тамга/

Тайлбар:.....  
.....  
.....

Их эрсдэлтэй >=50%  
Дунд эрсдэлтэй [30%-49%]  
Бага эрсдэлтэй <=29%